



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/59

Баян-Адарга сум

Хагас жилийн мал тооллого явуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баян-Адарга сумын нутаг дэвсгэрт хагас жилийн мал тооллогын ажлыг 2025 оны 06 дугаар сарын 04-ноос 2025 оны 06 дугаар сарын 10-ний хооронд явуулсугай.

2. 2025 оны Хагас жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулах сумын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Ганбат (Сумын Засаг даргын орлогч)
Гишүүд: О.Жаргалцэцэг (Татварын улсын байцаагч)
С.Энхцэцэг (Нийгмийн даатгалын байцаагч)
Э.Оюунтунгалаг (Мал эмнэлгийн тасгийн дарга)
Ө.Энхзул (Газрын даамал)
Г.Намсрай (Сайхан багийн засаг дарга)
Г.Жавзмаа (Жаргалант багийн засаг дарга)
Н.Цолмонбаяр (Адарга багийн дарга)
М.Нямдорж (Дуурлиг багийн дарга)

Нарийн бичгийн дарга: Д.Дуламсүрэн (Төлбөр, тооцоо хариуцсан мэргэжилтэн)

3. Хагас жилийн мал тооллогын ажлыг хуулийн хүрээнд хугацаанд нь чанартай зохион байгуулж, ажлын хэсэгт мэргэшил, арга зүйн зөвлөмж өгч, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг сумын Засаг даргын орлогч бөгөөд ажлын хэсгийн ахлагч (Н. Ганбат)-д үүрэг болгосугай.

4. Хагас жилийн мал тооллогыг сумын хэмжээнд зохион байгуулахад шаардлагатай заавар зөвлөмжийг өгч тооллогыг нэгэн зэрэг хугацаанд нь эхлүүлж, чанартай зохион байгуулахад хяналт тавьж ажиллахыг Нарийн бичгийн дарга (Д.Дуламсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.ЛХАГВАДОРЖ

